

БАТЛАВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Т.ЖАРГАЛСАЙХАН

“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

**ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОХ
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №48/2020**

2020 оны 05 дугаар сарын 07

1. Хэрэглэгчийн нэг, хаяг: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын засаг даргын тамгын газар
2. Техникийн нөхцөл авах объектийн нэр, байршил: Цогтцэций сумын төвийн шинэ Өгөөмөр хүүхдийн талбайн баруун зүүнталд баригдах 20 айлын орон сууц.
3. Хэрэгцээт хүчин чадал: (урьдчилсан тооцоогоор) **120кВт**
4. Хэрэглэгчийн ажлын горим: **24 цаг**
5. Хэрэглэгчийн зэрэг: **Гурав**
6. Холбогдох цэг: Өгөөмөр хүүхдийн талбайн зүүн байр 1 10/0.4кВ ТП-5 дэд станцын хойд гаргалгаа 10 дахь тулгуур.
Өгөөмөр хүүхдийн талбайн баруун байр 2 10/0.4кВ ТП-9 дэд станцын хойд гаргалгаа 4 дахь тулгуур.
7. Ерөнхий шаардлага:
 - 7.1 Хэрэглэгч нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээр зураг төслийг хийлгэнэ. Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцлийн дагуу зураг төслийг боловсруулж, “ӨБЦТС”ТӨХК-иар хянуулан зөвшилцөл хийж, зургийн 1 хувийг техникийн нөхцөл олгогчид өгнө.
 - 7.2 Зураг төсөлгүй буюу зөвшилцөл хийгээгүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.
 - 7.3 Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад газар доорхи инженерийн сүлжээг дайрч гарах зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлнэ. Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн сүлжээтэй тааралдаж байгаа бол түүнийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг нь хариуцах үүрэгтэй
 - 7.4 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу “ӨБЦТС” ТӨХК-ийн техникийн ажилтны хяналт, зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.
 - 7.5 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг хийж дууссаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан туршилт тохируулгын ажлыг хийж холбогдох акт баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:
 - Гүйцэтгэлийн зураг
 - Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд.

- Суурилагдсан тооцооны болон хяналтын хэмжүүрүүдийн паспорт, улсын баталгаажуулалтын гэрчилгээ.
- Туршилт тохируулгын баталгаажсан лабораторын акт бичиг баримт, ашиглалтын заавар.
- Кабелийн трассын координатын байршил, трассын зураг.

8. Зураг төсөл зохиох, угсралтын ажил гүйцэтгэхэд биелүүлэх шаардлага:

- ТП-5 дэд станцын одоо байгаа 10/0.4 кВ-ын 160 кВА чадалтай трансформаторыг 10/0.4 кВ-ын S-11 маркын 250 кВА чадал бүхий трансформатороор солих.
- 10/0.4 кВ ТП-63 дэд станцын 0.4 кВ шит хайрцгийг бүрэн шинэчлэх, шит нь IP-65 стандартыг хангасан битүүмжлэл сайтай байх. 0.4кВ шит нь 630А ерөнхий рубельник, гаргалгааны 250А-2ш, 200А-2ш, 180А-2ш автомат таслуур тоноглох. Трансформаторын буултын кабелийн хөндлөн огтлол 3*120+1*70 мм2 багагүй байхаар сонгож тооцох. Хэмжүүр болон тооцооны гүйдлийн трансформаторыг тус тусад нь монтажлах.
- Сольсон 10/0.4кВ 160кВА трансформатор, 0.4 кВ-ын шит хайрцагийг “ӨБЦТС” ТӨХК-н хашаанд бүрэн бүтэн буулгаж хүлээлгэж өгөх.
- Дэд станцын 0.4кВ шитэнд “ӨБЦТС” ТӨХК-н ухаалаг тоолуурын системд бүрэн нийцэж ажилладаг 3 фазын 5А тоолуур DTSD545S маркийн тоолуур суурилуулах, тоолуур нь олон улсын DLMS протокол дэмждэг, тухайн 10/0.4 кВ-ын дэд станцын мэдээлэл цуглуулах дата концентратортой PLC буюу хүчдэлийн шугамаар холбогдож мэдээллээ илгээдэг байх. Мөн GSM сүлжээгээр мэдээлэл дамжуулах сим картны оролттой байх. RS485, оптик холболтоор холбогдон тохиргоо үзлэг үйлчилгээ хийх боломжтой байх.
- 10/0.4 кВ ТП-5-н хойд гаргалгааны төгсгөлийн тулгуураас 12 метр төмөр бетон тулгуур 2 ш суурилуулж засмал зам дээгүүр давуулга хийх, 1ш дундийн тулгуур, 1ш төгсгөлийн төмөр бетон тулгуур суурилуулж, төгсгөлийн тулгуураас баригдах орон сууцны барилгыг хос кабель шугамаар сувагжилт хийж тэжээл татах. Кабель шугамын трассыг сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж зөвшөөрөл авах.
- Кабель шугамын хөндлөн огтлолыг ачааллаас хамааруулж сонгож тооцох.
- 10/0.4 кВ ТП-9-н хойд гаргалгааны 4 дахь тулгуураас шинээр суурилуулж баригдах орон сууцны барилгыг хос кабель шугамаар сувагжилт хийж тэжээл татах
- Айл өрхийн хэрэглээнд тус бүрд нь 1 фазын DTS-22 бүрэн электрон тоолуур монтажлах
- Орон сууцны барилга тус бүрд хоёр секц бүхий сэлгэн залгагчтай, засвар үйлчилгээ хийх боломжтой, газардуулах байгууламжтай иж бүрэн шит хайрцаг монтажлах.
- Барилгын 0.4 кВ-ын ерөнхий шит хайрцаг тус бүрд тооцооны болон хэмжүүрийн гүйдлийн трансформаторыг тус тусад нь монтажлах.

- Барилга тус бүрд нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлэг, гадна гэрэлтүүлэгт тусад нь ЦЭХ-ний 3 фазын 100А тоолуур DTS-122 маркийн тоолуур монтажлах.
 - Угсралтын ажлыг эхлэх үе шат бүрт хангагч байгууллагатай зөвшилцөж байх.
 - Шугам, дэд станц барих угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм болон Техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
 - Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлэх.
 - Гүйцэтгэлийн кадастрын зураг хийж хангагч байгууллагад хүлээлгэн өгөх.
9. Техникийн нөхцөл нь олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

10. Техникийн нөхцөлийг явуулсан газрууд:

Цогтцэций сумын засаг дарга О.Бадарч 89402260

11. Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙИНЖЕНЕР



Т.ГАНТӨМӨР

ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА



Б.ЧИНБАТ

ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВИЙН ДАРГА



Ц.НАРАНТУЯА

РЕЛЕ ХАМГААЛАЛТ,
ТОХИРУУЛГЫН И НЖЕНЕР

С.ЧУЛУУНБААТАР